



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 2/11

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

“Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Гэр бүлийн тухай” хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 13 дугаар багийн иргэн Г.Баасангийн асрамжинд байгаа бүтэн өнчин 14 настай О.Энхпүрэв, 6 настай О.Энхдалай нарыг өөрсдийн хүсэлтээр Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлах “Өнөр бүл” асрамжийн газарт шилжүүлсүгэй.

2. Асрамжийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн, хүлээлгэн өгч, хүүхдүүдийн талаар эргэн мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч (Х.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

3. “Өнөр бүл” асрамжийн газарт хүүхдүүдийг хүргэх унааны зардалд 100000 (Нэг зуун мянга) төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгөөс гаргахыг Нягтлан бодогч (Ж.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

371100021